



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-17

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

Аэродромын хэрэглэгчдийн бүлэг

2016 оны 4 сарын 15

Ерөнхий зүйл

Иргэний нисэхийн ерөнхий газрын зөвлөмжийн цувралууд нь холбогдох дүрмийн шаардлагуудад нийцсэн эсэх нь ИНЕГ-ын Даргаар зөвшөөрөгдсөн стандарт, аргачлал болон журмын талаарх мэдээллүүдийг агуулсан байна.

Дүрмийн шаардлагадуудад нийцсэн гэдэг нь зөвхөн холбогдох дүрмийн шаардлагатай холбож ойлгож болохгүй бөгөөд дүрмийн шаардлагыг биелүүлж болох өөр арга хэрэгслүүд ИНЕГ-ын Даргад танилцуулагдах боломжтой. Шаардлагатай тохиолдолд энэхүү зөвлөмжийн цувралд хамаарах шинэ стандарт, үйл ажиллагаа, журам нэмэгдэн орж болно.

Түүнчлэн энэхүү зөвлөмжийн цуврал нь дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий гарын авлага болох материалыг агуулдаг бөгөөд гарын авлага нь заавал дагаж мөрдөх албагүй юм.

Зорилго

Энэхүү зөвлөмжийн цуврал нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид хэрэглэгчдийн бүлгийг байгуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахад холбогдох зааварчилгаар хангах бөгөөд шаардлагатай нөхцөлд хэрэглэгчдийн бүлгийг илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болно.

Холбогдох дүрэм

Байхгүй

Өөрчлөлтийн тэмдэглэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-139-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

ЗЦ139-17-г NZ АС139-17-гийн 2012 оны 7 сарын 20-ний өөрчлөлт 0-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

Танилцуулга	4
Хэрэглэгчдийн бүлгийн бүрэлдэхүүн	5
Хэрэглэгчдийн бүлгийн үйл ажиллагаа	5
Ерөнхий зүйл	5
Хэрэглэгчдийн бүлгийг байгуулах нь	6
Давтамж.....	6
Хөтөлбөр	6
Авах арга хэмжээ	7
Хурлын тэмдэглэл.....	7
Нисэхийн судалгаа.....	7

Танилцуулга

Аэродромын хэрэглэгчид тогтмол уулзаж тулгамдсан асуудал, аливаа өөрчлөлтүүдийг хянах, баталгаажуулах, аюулгүй ажиллагааг сайжруулах зорилтуудыг хамтдаа хэлэлцэж эхэлсэнээр аэродромын аюулгүй ажиллагаа эрс дээшилдэг. Аэродромд мэдээлэгдсэн нисэхийн холбоотой олон тооны асуудлууд болон осол зөрчлүүдийг аэродромын үйл ажиллагаа эрхлэгч аэродромын хэрэглэгчдийн бүлэг байгуулж ашигласанаар багассан гэдэг нь туршлагаар батлагдсан болно. Энэ нь аюулгүй ажиллагааны тулгамдсан асуудлуудыг таних тогтоох, аэродромын ашиглалтанд ямар нэгэн үйл ажиллагааны нөхцөл болон хязгаарлалтыг боловсруулах хэлбэр юм.

ИНЕГ бүх аэродромууд дээр аэродромын хэрэглэгчдийн бүлгийг бүрдүүлэх болон хэрэглэхийг хүчтэйгээр дэмждэг. Аэродром болон орчмын агаарын зайн үйл ажиллагаанд оролцон ажилладаг бүлэг хүмүүсийн дуу хоолойгоор илэрхийлэгдэж буй тулгамдсан асуудлууд болон холбогдох зөвлөмжүүдийг маш нухацтайгаар хүлээн авдаг.

Аэродромын хэрэглэгчдийн бүлэг нь аэродромын хэрэглэгчдээс илэрхийлэгдсэн аюулгүй ажиллагааны асуудлуудад анхаарал хандуулах хамгийн шилдэг хэлбэр бөгөөд ямар нэгэн төлөвлөгдсөн өөрчлөлт нь аэродромын орчимд үзүүлэх нөлөөлөл, аэродром дээр явагдаж буй үйл ажиллагааны төрөл, шаардлагатай үед нисэхийн мэдээллийн эмхэтгэлд зарлагдсан үйл ажиллагааны нөхцлүүдийг хянах, шинэчлэх зэрэг асуудлуудыг хэлэлцдэг.

Хэрэглэгчдийн бүлгийн зорилго нь аэродромын болон түүний агаарын зайн ашиглалтын аюулгүй ажиллагааны процедурын зохицуулалт, боловсруулалтыг дэмжих юм. Гол зорилго нь аэродром дээр үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагааны төрөл болон тодорхой бүсүүдэд тохирсон процедуруудыг эзэмших, ашиглах явдал юм. Энэ нь “Оролцогчдын үүрэг хариуцлага” гэж бас тодорхойлогддог.

Энэ нь бас аэродромын ашиглалтын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны бас нэгэн чухал бүрдэл юм.

Зөвлөмжийн цувралын зорилго нь аэродромын хэрэглэгчдийн бүлгийг байгуулах, үйл ажиллагааг явуулахад холбогдох зааварчилгаар хангахад оршино. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны зөвлөгчид нь шаардлагатай бол туслалцаа үзүүлэх боломжтой байдаг. ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын албатай холбоо тогтоох вэб хуудсыг дор үзүүлэв.

<http://mcaa.gov.mn>

Хэрэглэгчдийн бүлгийн бүрэлдэхүүн

Аэродромын холбоотой ашиглалтын ажлын бүтээмж, тогтмолжилт, аюулгүй ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл ажиллагаа явуулдаг бүх хүмүүс болон байгууллагуудын төлөөллүүдийг аэродромын хэрэглэгчдийн бүлэгт багтаасан байвал зохино. Дараах төлөөллүүд нь бүрэлдэхүүнүүд багтах бөгөөд үүнд:

- Хуваарьт нислэг бүхий агаарын тээвэрлэгчид
- Орон нутгийн агаарын хөлгийн операторууд
- Нисдэг тэрэгний операторууд
- Нислэгийн сургуулиуд
- Агаарын тээвэрлэгчдийн холбоо
- Нисэх төхөөрөмжийн клубууд
- Делтаплан клубууд
- Шүхрийн байгууллагууд
- Нисэх загварын клубууд
- Гадны гэрээт байгууллагууд /өвс хадах, зэрлэг устгах, зам талбай засварлах гэх мэт/
- НААХЗА-ны аюулгүй ажиллагааны зөвлөгчид болон бусад ажилтанууд

Дээрх бүх байгууллагууд нь өөрсдийн ямар нэгэн хэрэгцээ шаардлагатай бөгөөд бусдын үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц зүйлсийг нийцүүлж ажиллах шаардлагатай. Хэрэв эдгээр хэрэгцээ болон үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн бүлэгт хэвшсэн бөгөөд аэродромын үйл ажиллагаа явуулах зөвшилцөл бий болсон үед аюулгүй ажиллагаа, ажлын бүтээмж нэмэгдэх сайн талтай.

Хэрэглэгчдийн бүлгийн үйл ажиллагаа

Ерөнхий зүйл

Иргэний нисэхийн салбарт маш олон хэрэглэгчдийн бүлгийн үр дүнтэй үйл ажиллагаа байдаг бөгөөд нэг чиглэлд 2 өөр бүлэг байдаггүй болно. Эдгээр нь аэродромын тодорхой орчинд үйл ажиллагаа нь хамгийн сайн нийцсэн байгууллагууд болсон байдаг.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь эцсийн дүндээ аюулгүй ажиллагааны хамгийн гол хариуцлагыг хүлээх бөгөөд нислэгийн үйл ажиллагааны нөхцлүүд болон хязгаарлалтуудыг тогтоох, зарлах үүрэгтэй. Гэвч дээрх үйл ажиллагаануудыг зохицуулах үүрэг нь аэродромын эрхлэгчээс илүү нислэгийн үйл ажиллагааны туршлага, мэргэжил бүхий аэродром дээр үйл ажиллагаа явуулдаг бусад операторуудад ихэвчлэн шилждэг.

Хэрэглэгчдийн бүлгийг байгуулах нь

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь холбогдох бүх ажилтнуудыг урьж анхны уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй. Хэрэв хүсэлт гаргасан тохиолдолд ИНЕГ-ын Аюулгүй ажиллагааны зөвлөгч холбогдох зааварчилгааг өгөх үүрэгтэй. Хэрэглэгчдийн бүлгийн зорилго нь тодорхой тайлбарлагдаж, оролцогчид нь аюулгүй ажиллагаа болон агаарын хөлгийн үйл ажиллагаа тогтмолжилтийг сайжруулж болох боломжтой газруудад зочилж танилцана.

Эдгээр яригдсан зүйлсийн дагуу ямар нэгэн хүн хэрэглэгчдийн бүлгийн даргаар сонгогдох шаардлагатай бөгөөд энэ нь заавал аэродромын үйл ажиллагаа эрхлэгч байх албагүй юм. Хэрэглэгчдийн бүлгийн дараагийн уулзалтын тов, үүссэн асуудлуудыг шийдвэрлэх, засах зэрэг хийх ажлын төлөвлөгөө батлагдсан байвал зохино.

Давтамж

Хэрэглэгчдийн бүлгийн уулзалт нь аэродромын үйл ажиллагааны зэргэлэл, нөхцлөөс хамаарч тодорхой хугацааны давтамжтайгаар товлогдсон байна. Хэрэв аэродромын зэрэглэл болон нөхцөл нь өндөр бол уулзалтыг жилд 6 хүртэл удаа товлоно. Аэродром нь зөвхөн нэг хуваарьт нислэгтэй үед 1 жилд 2 удаа уулзах нь зохимжтой.

Аэродром дээр шинэ үйл ажиллагаа эрхлэгч болон шинэ ашиглалтын нөхцөл зарлагдах, ноцтой асуудал үүсэх, осол, зөрчил гарах үед тусгайлсан уулзалтуудыг зохион байгуулна.

Хөтөлбөр

Уулзалт бүрийн өмнө хөтөлбөр тодорхой болсон байх бөгөөд хэрэглэгчдийн бүлгийн гишүүн бүрт тараагдсан байна. Энэхүү хөтөлбөр нь тухайн уулзалтын стандарт байх бөгөөд зөвхөн шаардлагатай үед л өөрчлөлт хийгдэнэ.

Хэрэглэгчдийн бүлгийн уулзалтанд яригдах зүйлс нь:

- Нисэх буудлын үйл ажиллагааны асуудлууд
- Аэродромын планд орох өөрчлөлтүүд болох хийгдэхээр төлөвлөгдсөн ажлууд
- Агаарын зайн асуудлууд
- Аюулгүй ажиллагааны осол, зөрчлийн хяналт
- Нисэхийн мэдээллийн эмхэтгэл дэх аэродромын зарлагдсан мэдээлэл, үйл ажиллагааны процедурын хяналт
- Агаарын зайн ямар нэгэн төлөвлөлтийн өрчлөлтийн зохицуулалт болон хяналт
- Тусгай хэрэгцээт байгууллагад зохицсон нислэгийн хөдөлгөөний дүрмийн шаардлага. Делтаплан, нисдэг тэрэгний сургалт, нисэх загвар гэх мэт.
- Аэродромын үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц ямар нэгэн төрлийн үйл ажиллагааг эхлүүлэх болон дуусгах.
- Өмнө нь тусгай процедуртайгаар боловсруулагдсан болон цаашид үргэлжлэхгүй үйл ажиллагаанууд

- Бүлгийн ямар нэгэн гишүүний гаргасан асуудлууд

Авах арга хэмжээ

Ямар нэгэн асуудал үүсээд түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ нь төлөвлөгдсөн бол аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь дээрх төлөвлөж буй ажил нь ИНД-139 болон иргэний нисэхийн буусад хууль, дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй эсхүл ИНД-139 ийн дагалдах баримт бичгүүдтэй харшлахгүй болохыг баталгаажуулах хэрэгтэй.

Төлөвлөсний дагуу авах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд асуудал үүссэн бол аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь арга хэмжээг авахаас өмнө ИНЕГ-тай зөвшилцөх шаардлагатай.

Хурлын тэмдэглэл

Ирээдүйд хэрэглэх баримт болгон хадгалах зорилгоор уулзалт бүр дээр хурлын тэмдэглэл хөтлөгдсөн байна. Авах арга хэмжээ нь зөвшөөрөгдөж, холбогдох шийдвэрүүд гарсан үед хурлын тэмдэглэл дээр гарсан шийдвэрүүд болон дараагийн авах арга хэмжээнд хэн үүрэгтэй болох нь маш тодорхой тэмдэглэгдэнэ. Хурлын тэмдэглэл нь бүлгийн гишүүн бүрт аль болох хурдан тараагдах бөгөөд дараагийн уулзалтаар гишүүд нь ямар нэгэн шаардлагатай арга хэмжээ авах боломжтой эсэхийг баталгаажуулна.

Нисэхийн судалгаа

Нисэхийн судалгаа нь аэродром болон агаарын зайн процесс болон аюулгүй ажиллганауудын шаардлагууд бүрэн тавигдсан эсэхийг баталгаажуулах хяналтын хэрэгсэл юм. Хэрэглэгчийн бүлгийн гишүүд нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид аэродромын орчинд ямар нэгэн өөрчлөлт хийхээр төлөвлөх үед тусласнаар нисэхийн судалгаа болон аюулгүй ажиллагааны хяналт хийхэд мөн туслах боломжтой болно.

Зөвлөмжийн цуврал ЗЦ139-5 аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон бусад хүмүүс нисэхийн судалгааны ажлыг гүцэтгэхэд гарын авлага, холбогдох мэдээллүүдээр хангадаг.

--oOo--